

## ТАНИЛЦУУЛГА

### “ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ

2024.01.19

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 -д заасан чиг үүргийн дагуу “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 02 тоот тогтоолоор батлан гаргаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр 5060 дугаартайгаар бүртгэснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн болно.

Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д тус хуульд нийцүүлэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан баталж, Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийлгэн, даган мөрдөж байна.

Тус Хорооноос “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”, “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” зэрэг баримт бичгүүдэд Хорооны даргын 2023 оны А/182 тоот тушаалын хавсралтаар баталсан “Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж”-ийн дагуу 2023 оны 4 дүгээр улиралд үнэлгээ хийж, хэрэгжилтийн байдлыг гарган тайланг Даргын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлсэн.

Баримт бичигт хийсэн дүн шинжилгээгээр баримт бичгийн зүйл заалт тус бүрийн хэрэгжилтийг Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлөөр хүлээсэн үүрэг, хөтөлбөрийн биелэлт, зар сурталчилгааны зохицуулалт, нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн байдлыг гаргаж, үнэлгээ хийсэн болно.

“Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээнд Улаанбаатар хот болон орон нутагт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа телевизийн үйлчилгээ эрхлэгчийн хөтөлбөрөө дахин дамжуулж байгаа хамрах хүрээний асуудлыг мөн авч үзсэн.

Орон нутгийн телевизүүдийн тухайд хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжуулан зөвхөн тусгай зөвшөөрөлд заасан буюу өөрийн аймагт хүргэх боломжтой харин бусад аймаг, сумдад дахин дамжуулах нь хязгаарлагдмал байгаа.

Орон нутгийн ард иргэдэд тухайн аймаг, бүс нутагт болж байгаа үйл явдлын мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авах хэрэгцээ шаардлагын үүднээс аймаг, орон нутагт радио, телевизийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байдаг.

Сүүлийн 2 жилийн хугацаанд орон нутагт үйл ажиллагаа эрхлэх телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүйн улмаас өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрлөө цуцлуулах хүсэлтийг 7 үйлчилгээ эрхлэгч гаргаж, шийдвэрлүүлсэн байна.

Тус Хорооны зүгээс 2023 онд телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг 2 удаагийн сонгон шалгаруулалтаар 8 аймагт зарласан боловч ердөө 2 аймагт хүсэлт ирж тусгай зөвшөөрөл олгогдсон бол бусад 6 аймагт хүсэлт ирээгүй, тухайн орон нутгийнхаа мэдээ мэдээллийг телевизийн үйлчилгээгээр дамжуулан авах боломжгүй хэвээр байна.

Түүнчлэн аймаг, орон нутгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчийн зүгээс “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 2.6 дахь заалтаар аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийн хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглосон заалтыг эргэн харж тухайн бүс нутаг, зэргэлдээ аймагтаа үйлчилгээгээ хүргэх боломжийг олгож өгөх хүсэлтийг тавьдаг.

Иймд тус Хорооны зүгээс 2023 оны баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ, үйлчилгээ эрхлэгчдийн зүгээс тавьдаг санал, хүсэлт болон жил бүр гаргадаг “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдалд хийсэн үнэлэлт, дүгнэлт” зэрэгт үндэслэн “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-ийн дагуу олон нийтээс санал авахаар нээлттэйгээр байршуулж байна.

**Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 02 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл**

**ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХҮРЭЭ, БАЙРШИЛ**

2.1. Телевизийн үйлчилгээг тодорхой бүс нутагт эрхлэх тохиолдолд үйл ажиллагаа явуулах газарзүйн байршлаар үйлчилгээ эрхлэх хүрээг Улаанбаатар хот, тухайн аймгийн нутаг дэвсгэрт гэж тогтоох ба тусгай зөвшөөрөл, гэрээнд тусгайлан заана.

2.2. Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг Багануур, Налайх, Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт телевизийн үйлчилгээ эрхлэх тохиолдолд тусгай зөвшөөрөлд үйлчилгээ эрхлэх хүрээг тухайн алслагдсан дүүргийн нутаг дэвсгэрт гэж заана.

2.3. Телевизийн үйлчилгээг олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр дамжуулан Улаанбаатар хот болон бүх аймагт хүргэх тохиолдолд үйлчилгээ эрхлэх хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт гэж тогтооно.

2.4. Тухайн аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевизийн үйлчилгээ эрхлэгч нь хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээний сүлжээгээр дахин дамжуулан бусад аймагт хүргэх тохиолдолд Зохицуулах хороо үйлчилгээ эрхлэх нэмэлт хүрээг тусгай зөвшөөрөлд нэмж заана.

2.5. Монгол Улсын нутаг дэвсгэрт болон энэ нөхцөл шаардлагын 2.4-д заасан хүрээнд үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрөлд заасан байршилд үйл ажиллагаа явуулна.

2.6. Үйлчилгээ эрхлэх хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад ирүүлсэн хүсэлтийг үнэлэхдээ дамжуулах сүлжээний багтаамж, техникийн боломж, үйл ажиллагааны төлөвлөлт зэргийг харгалзан үзнэ.

2.7. Зохицуулах хороо нь энэ нөхцөл шаардлагын 2.4-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн хүсэлтээр эсхүл тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт, хяналт, мониторингийн тайланд үндэслэн үйлчилгээ эрхлэх нэмэлт хүрээг бууруулна.

**Хоёрдугаар зүйлийг шинэчлэн найруулсантай холбогдуулан:**

**[1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төсөл:](#)**

1.4. Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасан зарчмын дагуу сонгон шалгаруулалтаар олгохдоо үйлчилгээ эрхлэх хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт, Улаанбаатар хот, эсхүл Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг, Тухайн аймгийн нутаг дэвсгэрт гэж тогтооно.

**[3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төсөл:](#)**

3.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт телевизийн үйлчилгээ эрхлэх сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах нөхцөлийг хангана.